C. Этилийн спирт
D. Метилийн спирт
E. Цууны хүчил
- /194./ Хорт бодис гэдэг нь бие махбодид
A. Эмчилгээний тунгаар орж эмчилгээний үйлдэл үзүүлдэг.
B. Хамгийн бага тунгаар орж эмчилгээний үйлдэл үзүүлдэг
C. Хамгийн бага тунгаар орж хордлого үүсгэх
D. Эмчилгээний тунгаар орж хордлого үүсгэх
E. Эмчилгээний тунгаар орж үйлдэл үзүүлдэггүй
- /195./ Минерализацийн хуурай үнсжүүлэх арга ямар зарчим дээр үндэслэгддэг вэ?
A. Биоматериалыг бүрдүүлж буй органик бодисыг хүчлээр исэлдүүлэх

- В. Биоматериалыг өндөр хэмд шатаах
С. Биоматериалыг бүрдүүлж буй органик бодисыг нитритын оролцоотойгоор хайлуулах
D. Биоматериалыг бүрдүүлж буй органик бодисыг нитратын оролцоотойгоор хайлуулах
E. Биоматериалыг бүрдүүлж буй органик бодистой конц. Хүхрийн хүчлийг урвалд оруулах
- /196./ Фенобарбиталын хордуулах тунг заана
A. 1-1.5 гр
B. 0.6-1 мг
C. 1.5-2 гр
D. 1-3 мг
E. 0.6-1 гр
- /197./ Формальдегидийн метаболизмийн дүнд үүсэх нэгдлийг нэрлэнэ үү.
A. Хурган чихний хүчил
B. Цууны хүчил
C. Нүүрсхүчлийн хий
D. Метаболизмд оролгүй гадагшилна
E. Шоргоолжны хүчил
- /198./ Цусанд угаарын хийг тодорхойлоход ямар урвалд хэрэглэн, ямар өнгө илрэх ёстой вэ?
A. 10% KOH, хордсон цусны өнгө хэвээр
B. 2% H₂SO₄, хордсон цусны өнгө саарал болно
C. 30% KOH, хордсон цусны өнгө хэвээр
D. 30% NaOH, хордсон цусны өнгө хэвээр
E. 30% NaOH, хордсон цусны өнгө саарал болно
- /199./ Усны уураар нэрэх аргаар биоматериалаас хорт бодисуудыг ялгахдаа эхний нэрэгдсийг
A. 2%-ын FeCl₃
B. 2%-ын NaOH
C. 2%-ын HCl
D. 2%-ын Na₄[Fe(CN)₆]
E. нэрмэл ус бүхий саванд тосч авдаг
- /200./ Зүрхний гликозидыг биоматериалаас ялгахад ямар уусгагч хэрэглэдэг вэ?
A. Метилийн спирт
B. Хлороформ
C. Этилийн спирт
D. Диэтилийн эфир
E. Нэрмэл ус
- /201./ Синилийн хүчлийг илрүүлэх чанарын урвалын дүнд ямар нэгдэл үүсэх вэ?
A. Мурексид
B. Берлинский лазурь
C. Цианидин
D. Амигдалин
E. Таллейохин
- /202./ Синилийн хүчил организмд орсны дараа цусны ямар элементтэй нэгддэг вэ?
A. Цагаан эс
B. Эритроцит
C. Цусны бөөм
D. Гемоглобин
E. Уураг
- /203./ Минерализатын тундаст агуулагдах хар тугалгыг баригаас яаж тусгаарладаг вэ?
A. Тундас дээр H₂S нэмнэ
B. Na₂S нэмнэ
C. NaOH нэмнэ
D. NH₄OH нэмнэ
E. CH₃COONH₄ нэмнэ

/204./ Хүчилжүүлсэн спиртээр биоматериалаас алкалоид ялгах орчин үеийн аргад орчны рН хэд байхыг шаарддаг вэ?

- A. рН=2.5-3
- B. рН=3-4
- C. рН=1-2
- D. рН=2-2.5
- E. рН=4-5

/205./ Метилийн спирт организмд этилийн спирттэй хамт орсон тохиолдолд

- A. Метилийн спиртийн хоруу чанар ихэснэ.
- B. Метилийн спиртийн хоруу чанар илрэхгүй.
- C. Метилийн спиртийн хоруу чанар 50% буурна.
- D. Метилийн спиртийн хоруу чанар этилийн спиртээс хамаарахгүй
- E. Метилийн спиртийн хоруу чанар 10% буурна

/206./ Дараах бодисуудаас алиныг нь биоматериалд шууд тодорхойлох вэ?

- A. CO
- B. NH₃
- C. NaCl
- D. NaOH
- E. HCl

/207./ Металл хоруудыг биоматериалаас ялган авахад ямар аргыг ашигладаг вэ?

- A. Хүчилжүүлсэн усаар ялгах
- B. Хүчилжүүлсэн спиртийн уусмалаас хандлах
- C. Минерализацийн арга
- D. Усаар хандлах
- E. Биоматериалд шууд тодорхойлох

/208./ Хэвийн үед хүний хоногийн шээсэнд хэдэн мг ацетон агуулагдаж болох вэ?

- A. 10-20
- B. 20-30
- C. 40-50
- D. 45-55
- E. 35-50

/209./ Азотын ба хүхрийн хүчлийн тусламжтай минерализаци явуулахад эрдэс хүчлүүдийг ямар харьцаагаар авдаг вэ?

- A. 1:1
- B. 1:2
- C. 1:12
- D. 2:1
- E. 1:10

/210./ Бодисын гэрлийн хугарлын илтгэгчийг ямар багажаар тодорхойлдог вэ?

- A. Поляриметр
- B. Гемометр
- C. Рефрактометр
- D. Оксигемометр
- E. Фотометр

/211./ Ямар замаар биед орсон хорт бодисын үйлдэл хурдан илэрдэг вэ?

- A. Хоол боловсруулах
- B. Амьсгал
- C. Арьс
- D. Хөндий эрхтэн
- E. Арьс, хөндий эрхтэн

/212./ Шүлтлэг уусмалаас авсан хлороформын ханданд ямар бодисуудыг тодорхойлох вэ?

- A. Барбитурат
- B. Изохинолины уламжлалын алкалоид
- C. Салицилын хүчил
- D. Тропаны уламжлалын алкалоид
- E. Пурины уламжлалын алкалоид

/213./ Хараанд нөлөөлөх метилийн спиртийн тун аль нь вэ?

- A. 10-15 г
- B. 7-8 г
- C. 15-20 г
- D. 3-5 г
- E. 0.7-0.8 г

/214./ Шүлтлэг уусмалаас хлороформоор хандласан уусмалаас хэдэн дуслыг авч ууршуулан, хуурай үлдэгдлийг усанд уусгаж 10% хүхрийн хүчлээр хүчилжүүлэн натрийн нитритийн ханасан уусмал нэмэхэд ногоон өнгө үүссэн бол ханданд ямар нэгдэл агуулагдаж байсан бэ?

- A. Папаверин
- B. Амидопирин
- C. Хинин
- D. Антипирин
- E. Морфин

/215./ Конгийн цаас хөх болох нь биоматериалд ямар бодис байгааг илэрхийлэх вэ?

- A. Биоматериалын хүчиллэг исэлдлийн бүтээгдэхүүн
- B. Гадны хүчил
- C. Гадны шүлт
- D. Биоматериалд шүлтлэг исэлдлийн бүтээгдэхүүн
- E. Гадны хүчил, шүлт

/216./ Дараах бодисуудын алиныг нь биоматериалаас усаар хандлан ялгаж авдаг вэ?

- A. Атропин
- B. Хүхрийн хүчил
- C. Гликозид
- D. Салицилийн хүчил
- E. Барбитурат

/217./ Мэдрэлийн мэс ажилбарын багажийг сонгон заана уу?

- A. Пульпэкстрактор
- B. Экскаватор
- C. Элеваторы
- D. Коловорот массивный
- E. Распатор

/218./ Дараах багажнуудаас чихний хэнгэргэн хальсны бүтэн эсэхийг тодорхойлоход аль нь хэрэглэгддэг вэ

- A. Воронка ушная / ушное зеркало
- B. Рефлектор лобный симановского
- C. Воронка ушная пневматическая
- D. Иглы парацениезные
- E. Щипцы тампонные ушные

/219./ Дараах багажны аль нь ерөнхий мэс ажилбарын багажинд хамаарагдахгүй вэ?

- A. Скальпели
- B. Ножи хирургические
- C. Элеваторы
- D. Долото
- E. Пила рамочная

/220./ Халдваргүйжүүлэх уур үүсгэгч аппаратыг заана уу

- A. Гидропульты
- B. Распылитель вентиляторный ручной (РВ-1)
- C. Аппарат “ Дезинфаль ”
- D. Аппарат для получения параформалина
- E. Пневматический опрыскиватель типа “ Автомакс ”

/221./ Склеренхим ямар эсээс тогтох вэ

- A. паренхим
- B. хлоренхим
- C. прозенхим

- D. аэронхим
- E. склереид

/222./ Дараах багажны аль нь ерөнхий мэс ажилбарын багажинд хамаарагдах вэ?

- A. Пульпэкстрактор
- B. Экскаватор
- C. Элеваторы
- D. Игла корневая
- E. Игла лигатурная

/223./ Дараах багажны аль нь эмэгтэйчүүдийн эмчилгээний багажинд хамаарагдах вэ?

- A. Зонд зобный
- B. Щипцы пулевые
- C. Экскаваторы
- D. Долото
- E. Пила листовая

/224./ Мэс заслын оёдлын материалуудаас аль нь дотуур оёдолд хэрэглэгддэг вэ / эдэд шимэгддэг

- A. Шелк хирургический
- B. Нитки капроновые
- C. Кетгут
- D. Нитки льняные
- E. Волос конский

/225./ Дотуур харах дараах дурангуудын алины нь бүрдэл хэсэгт троакар байх шаардлагатай вэ?

- A. Уретроскопи
- B. Троакаскопи
- C. Ректоскопи
- D. Цистоскопи
- E. Гастроскопи

/226./ Чих хамар хоолойн эмчилгээний багажийг сонгон заана уу?

- A. Шпатель нейрохирургический
- B. Наконечники для бормашин
- C. Зеркало-подъемник
- D. Тонзиллотом
- E. Ранорасширитель брюшной

/227./ Цусан дахь дүрст элементийн тоог дараах багажуудын алиныг нь хэрэглэж тогтоох вэ

- A. Гемометр
- B. Гемоцитометр
- C. Колориметр
- D. Оксигемометр
- E. Аппарат Панченков

/228./ Давсагыг дурандахад болон давсанд эмчилгээ хийхэд дараах багажны алиныг хэрэглэх вэ?

- A. Ректоскопи
- B. Троакаскопи
- C. Уретроскопи
- D. Цистоскопи
- E. Гастроскопи

/229./ Цитоплазмын гадаад, дотоод мембраныг нэрлэ.

1. гиалоплазм
2. плазмалемм
3. феллем
4. тонопласт
5. фелодерм

/230./ Рибосомын бүрэлдэхүүнийг хэлнэ үү.

1. полисахарид
2. уураг

3. нуклейн хүчил
4. рнк
5. днк

/231./ Иргэн байгаль орчныг хамгаалах талаар ямар үүрэг хүлээх вэ?

1. байгаль орчинд хортой нөлөөлөх үйл ажиллагааг таслан зогсоох
2. байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгжийг зөвшөөрөл олгохгүй байх асуудлыг холбогдох байгууллагад тавих

3. байгалийн нөөцийн байдалд хяналт тавих
4. байгаль орчинд хортой нөлөөлөлөөс сэргийлэх
5. байгалийн баялгийн ашиглалтанд хяналт тавих

/232./ Амсар ямар үүрэгтэй вэ?

1. бодисыг дамжуулах
2. усны ууршилтыг зохицуулах
3. бодисыг ялгаруулах
4. хийн солилцоо хийх
5. бодисыг хадгалах

/233./ Перидермийн үндсэн бүрэлдэхүүн хэсгийг нэрлэнэ үү?

1. феллодерм
2. феллоген
3. феллем
4. эпидерм
5. эпиблем

/234./ Ургамлын эсийн ханын найрлаганд ордог бодисыг нэрлэ.

1. пектины бодис
2. целлюлоз
3. гемицеллюлоз
4. оксалат кальци
5. крахмал

/235./ Электрон микроскопт харагдах органоидыг нэрлэ.

1. нуклеоплазм
2. гольджийн аппарат
3. лизосом
4. пластид
5. бөөм

/236./ Колленхим эсийн хана ямар найрлагатай вэ ?

1. целлюлоз
2. ус
3. пектин
4. уураг
5. гемицеллюлоз

/237./ Ургамлын хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт ямар үйл ажиллагаа явуулахыг хориглодог вэ?

1. хорио цээртэй нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх
2. Ургамлын гаралтай бүтээгдхүүнийг зөвшөөрөлгүй тээвэрлэх
3. хөнөөлийн голомтот байрыг зөвшөөрөл авалгүй ашиглах
4. ургамлын түүхий эдийг оруулах, дамжин өнгөрүүлэх
5. халдвартай үр суулгацыг тариалах

/238./ Фотосинтезийн процессд ямар бодисууд гол үүргийг гүйцэтгэх вэ?

1. хүчилтөрөгч
2. ус
3. нүүрстөрөгч
4. нүүрсхүчлийн хий
5. цардуул

/239./ Дамжуулах эд флоэмийн бүрэлдэхүүнд дараах элементүүдээс аль нь хамаарагдах вэ?

1. долонгийн паренхим

2. шигшүүрт хоолой
 3. дагуул эс
 4. ялгаруулах эс
 5. модлогийн паренхим
- /240./ ЭУТЭ-ээс полисахаруудыг юугаар ялгаж авдаг вэ?
- A. 95%-ийн спиртээр
 - B. Усаар
 - C. Эфирээр
 - D. Хлороформоор
 - E. Петролейний эфирээр
- /241./ Судас хатуурах өвчний үед хэрэглэгддэг ЭУТЭ-ийн фармакологийн үйлдлийг нэрлэ.
- A. Цусны холестеринийг багасгах
 - B. Тайвшруулах
 - C. Цэр ховхлох
 - D. Шээс хөөх
 - E. Даралт бууруулах
- /242./ ЭУТЭ-ийн чанарын тодорхойлолтод юу хамаарах вэ?
- A. Тоон үзүүлэлтүүд
 - B. Хадгалах хугацаа
 - C. ЭУТЭ-ийг бэлтгэх хугацаа
 - D. Фармакологийн үндсэн үйлдэл
 - E. Түүхий эдийн чанарын сорилтууд
- /243./ Протейдууд юунаас тогтох вэ.
- A. b -аминхүчил
 - B. ус
 - C. ионууд
 - D. липид
 - E. a- аминокүчил
- /244./ Ургамлын эд эсэд липидүүд дараахь үүрэгтэй
- A. Энерги, дулааны эх үүсвэр болох
 - B. Эд эсийг гадны таагүй нөлөөнөөс хамгаалах
 - C. Эд эсийн бодисын солилцоог зохицуулах
 - D. Тулгуур эдийн үүрэг гүйцэтгэх
 - E. Исэлдэн ангижрах урвалыг түргэсгэх
- /245./ ЭУТЭ-дэх эфирийн тосны тооны тодорхойлолтыг хэрхэн явуулдаг вэ?
- A. Усны ууртай нэрэх замаар
 - B. Энгийн нэрэх аргаар
 - C. Жин, эзэлхүүний аргаар
 - D. Чанарын урвалаар
 - E. Поляриметрээр
- /246./ Эмийн ургамлыг хэдэн хувийн чийглэгтэй болтол нь хатаах ёстой вэ.
- A. 10%
 - B. 15%
 - C. 12%
 - D. 5-10%
 - E. 10-12%
- /247./ Дараахь түүхий эдүүдийн аль нь алкалоид агуулдаг вэ.
- A. Марцны хоржигнуур
 - B. Алтанцэгцүүхэй
 - C. Гурван цэцэгт нил
 - D. Ээрэм шарилж
 - E. Алтан товч
- /248./ Ургамлын эсэд явагдах уургийн нийлэгжилт, эсийн өсөлт хөгжилт, удамших чанар нь ямар хүчлийн оролцоотойгоор явагддаг вэ.
- A. эрдэс хүчил
 - B. аминхүчил

- C. органик хүчил
- D. нуклеин хүчил
- E. ханасан хүчил

/249./ Хоёр бүрэлдэхүүнт ферментүүд нь юунаас тогтох вэ.

- A. Сахар
- B. Нүүрс-ус
- C. Кофермент
- D. Микроэлемент
- E. Энзим

/250./ Таван салаа ба ажигийн түүхий эд дэх биологийн идэвхит бодисыг ФК-д зааснаар ямар аргаар тодорхойлдог вэ?

- A. Спектрофотометр
- B. Жингийн аргаар
- C. Фотоэлектрокалориметрээр
- D. Саармагжуулах аргаар
- E. Хий-шингэний хроматографын аргаар

/251./ Ямар биологийн идэвхит бодис агуулсан ЭУТЭ-ийг гуурсан хоолойн үрэвсэлт өвчнийг эмчлэхэд хэрэглэдэг вэ?

- A. Фенологликозид
- B. Антрохинон
- C. Кумарин
- D. Салс
- E. Антроцен

/252./ Ургамалд биохимийн процесс явагдах хамгийн тохиромжтой орчин нөхцөл нь юу вэ.

- A. изотоник уусмал
- B. органик уусгагчийн орчин
- C. ус
- D. спирт
- E. хүчил

/253./ Ямар биологийн идэвхит бодис агуулсан түүхий эдэд биологийн стандартчилал явуулдаг вэ

- A. Алкалоид
- B. Эфирийн тос
- C. Зүрхний гликозид
- D. Антроцений уламжлалууд
- E. Экдизонууд

/254./ Амьд организмд хамгийн өргөн тархсан уургийг нэрлэнэ үү.

- A. альбумин
- B. фенил
- C. металлопротейд
- D. трипсин
- E. аланин

/255./ Марал цэцгийн түүхий эдийг ямар заалтаар хэрэглэж болдоггүй вэ?

- A. Бага насны хүүхдэд
- B. Архаг өтгөн хаталттай өвчтөнд
- C. Жирэмсэн эмэгтэйчүүдэд
- D. Янз бүрийн харшлын өвчтэй хүмүүст
- E. Өндөр настануудад

/256./ Ургамлын түүхий эдээс цэвэршүүлэн гаргаж авдаг төрөл бүрийн өөх тос ба өөх төст нэгдлүүд нь эм зүйн практикт дараахь байдлаар хэрэглэгддэг.

- A. Шахмал эмийн хэлбэрээр
- B. Органик уусгагчийн хэлбэрээр
- C. Галены бэлдмэлээр
- D. Лаа ба тосон түрхэцийн суурь
- E. Үрлийн наалдуулагч хэлбэрээр

/257./ Дараах нүүрс-устөрөгчдийн аль нь олигосахаридад хамаарагдах вэ.

- A. Биоз
- B. Мальтоз
- C. Триоз
- D. Фруктоз
- E. Глюкоз

/258./ Долоогоны бэлдмэл ямар нийлмэл эмийн найрлагад ордог вэ?

- A. Кардиовален
- B. Кордиамин
- C. Корвалол
- D. Кордафен
- E. Кордарон

/259./ Сапонин нь дараахь түүхий эдийн үндсэн үйлчлэгч бодис.

- A. Строфантын үр жимс
- B. Чихэр өвсний үндэс
- C. Алтан хундагын өвс
- D. Бамбайн үндэс ба үндэслэг иш
- E. Алтан гагнуурын үндэс ба үндэслэг иш

/260./ Бадааны бэлдмэлийг ямар үед хэрэглэж болохгүй вэ.

- A. Брадикардия
- B. Өтгөн хаталт
- C. Артерийн даралт ихдэх өвчин
- D. Артерийн даралт багадах
- E. Цэсний хүүдийн үрэвсэл

/261./ Ургамлын хэдэн хувийг ус эзлэх вэ

- A. 70%
- B. 90%
- C. 80%
- D. 85%
- E. 70-90%

/262./ Энгийн уургийг өөрөөр юу гэж нэрлэх вэ

- A. протейнууд
- B. аминхүчлүүд
- C. протейдууд
- D. рибонуклейд
- E. дезоксирибонуклейд

/263./ Флавоноид агуулсан ЭУТЭ-ийг ФК-д ямар аргаар стандартчилдаг вэ?

- A. Спектрофотометр
- B. Колориметр
- C. Потенциометрийн титрлэлт
- D. Перманганатометрийн титрлэлт
- E. Усны ууртай нэрэх

/264./ Пиримидиний ба пурины сууриуд юугаар ялгаатай вэ.

- A. эрдэс хүчил
- B. аминхүчлийн дарааллаар
- C. аминхүчлийн төрлөөр
- D. амин хүчлийн тоогоор
- E. физик шинж чанараар

/265./ Хий нь бүх биед гүйж амьдрах зүйн хөдөлгөгч хүч болдог ба хүмүүсийн нойр сэргэг, мартамтгай , хөдөлгөөнтэй бөгөөд тогтвор муутай байдаг онцлог шинж энэ нь хийн ямар билиг чанар вэ?

- A. Хөнгөн
- B. Хөлбөрөнхүй
- C. Ширүүн
- D. Сэрүүн
- E. Нарийн

/266./ Эмийн эрдэм гэж юу вэ зөв хариултыг сонгон уу.

- A. Хий, шар бадганыг дарах, үүсгэх ерөндөг
- B. Хий, шар, бадганад шууд чиглэгдсэн ерөндөг
- C. Хий шар бадганыг үүсгэх ерөндөг
- D. Хий, шар бадганы билэг чанарт шууд чиглэсэн ерөндөгийг хэлнэ.
- E. Хий шар бадганыг дарах ерөндөг

/267./ Ямар улиралын эхний 72 хоногт модон махбод идэвхжин үүнтэй уялдаад, элэгний үйл ажиллагаа идэвхжин түүнд шаардагдах шим тэжээл илүү ихээр үгүйлэгдэнэ.

- A. Хавар
- B. Намар
- C. Зун
- D. Өвөл
- E. Зун намрын зааг дээр

/268./ Дүрс байдал нь өндгөлжин бөөрөнхийвтөр буюу зууван хэлбэртэй 2- 2.5 см урт, 1- 1.5 см өргөн өнгөн тал нь боровтор улбараас улбарын хооронд өнгөтэй үрийн цөм идээ болно. ямар эмийн түүхий эд вэ? зөв хариултыг сонгоно уу.

- A. Задь
- B. Барүр
- C. Жүрүр
- D. Арүр
- E. Гагол

/269./ Лиш ямар өвчнийг дарах эмт бодисын ангилалд орох вэ зөв хариултыг сонгоно уу.

- A. Хийг үүсгэх эмт бодис
- B. Бадганыг дарах эмт бодис
- C. Шарыг арилгах эмт бодис
- D. Нянг нядлах эмт бодис
- E. Хийг дарах эмт бодис

/270./ Элгэнд ямар шар оршдог вэ? зөв хариултыг сонгоно уу

- A. Бүтээгч шар
- B. Үзүүлэгч шар
- C. Амь баригч шар
- D. Өнгө тодорхойлогч шар
- E. Өнгө урвуулагч шар

/271./ Хорыг тайлах, халууныг зогсоох, ундаасхыг арилгах, тайтгаруулах, хөхний хавдар дарах, идээ буглааг хатаана. Ямар амтын үйлдэл вэ зөв хариултыг сонгоно уу.

- A. Гашуун
- B. Гошгуун
- C. Исгэлэн
- D. Эхүүн
- E. Амтлаг

/272./ Сэтгэл санаагаар зовох, ямар нэг юмнаас айж цочиход хий үүсдэг зөв хариултыг сонгоно уу.

- A. Одон зурхайн таван махбодоос үүссэн хий
- B. Идээ, ундаанаас үүссэн хий
- C. Ум судлаас үүссэн хий
- D. Сэтгэлийн 3-н хороос үүссэн хий
- E. Явдал мөрөөс үүссэн хий

/273./ Амьтнаас гарах эмт бодисыг хэдий хугацаанд түүж авбал зохих вэ зөв хариултыг сонгоно уу.

- A. Намар, өвлийн халуун улиралд
- B. Намар, өвлийн сэрүүн улиралд
- C. Өвлийн сэрүүн улиралд
- D. Намрын сэрүүн дулаан улиралд
- E. 5-7 сарын хооронд сайн.

/274./ Ямар сургаал нь ерөнхийдөө хүний биеийн бүтцийг, мөн хүн байгаль хоёрын харилцаа холбоог тодорхойлдог вэ?

- A. Арга билгийн сургаал

- В. 3-н махбодын
- С. Хар зурхайн 5- махбодын
- Д. Одон зурхайн 5-н махбодын
- Е. Аюурведийн

/275./ Хорхойг хөөх ба туулгах эмийг хэдүй үед уулгах хэрэгтэй вэ?. зөв хариултыг сонгоно уу.

- А. Хоолны дараа
- В. Өлөн дээр нь
- С. Хоолны өмнө
- Д. Унтахын өмнө
- Е. Хоолтой хавсарган

/276./ Уламжлалт анагаах ухааны онолоор зүрх нь таван махбодын аль махбодод хамаарагдах вэ? Зөв хариултыг сонгоно уу.

- А. Гал
- В. Ус
- С. Огторгуй
- Д. Шороо
- Е. Хий

/277./ Уушигны цэцэг эрхтэн аль нь вэ? Зөв хариултыг сонгоно уу.

- А. Хэл
- В. Нүд
- С. Чих
- Д. Уруул
- Е. Хамар

/278./ Язгуурын шар буюу тус бүрийн шараас шингээгч шар нь ямар эрхтэнд оршдог вэ?

- А. Элгэнд
- В. Ходоодонд
- С. Гэдсэнд
- Д. Зүрхэнд
- Е. Арьсанд

/279./ Сэтгэл санааны байдал, 5-н мэдэрхүйн эрхтэнтэй холбоотой хий махбодын бөөгнөрөл бие махбодын аль хэсэгт оршдог вэ?

- А. Сүүж бэлхүүсэнд
- В. Биеийн доод хэсэгт
- С. Олгойд
- Д. Уушгинд
- Е. Зүрхэнд

/280./ Тулай хэрэх, уяман өвчин, хамуу, нясуу, хожигор, үлд зэрэг арьсны хорхойн өвчин болон булингартсан , халууныг арилгах эмт бодисыг ямар эмийн бүлэгт хамруулах вэ?. зөв хариултыг сонгоно уу.

- А. Шарыг арилгах
- В. Хорхойн өвчнийг арилгах
- С. Бадгана өвчнийг анагаах
- Д. Цусны өвчинг анагаах
- Е. Шар усны өвчинг анагаах

/281./ Шинц хэмээн нэрэлдэг эмийн ургамлын ямар хэсгийг авч эмэнд хэрэглэдэг вэ. зөв хариултыг сонгоно уу.

- А. Хальсны хагийг
- В. Холтосны гадар хальс
- С. Хальс, буюу холтос
- Д. Хальс буюу холтосны гадар хаг
- Е. Иш, мөчирний хальс

/282./ Хүний биеийн өтгөн, шингэн нь биеэс гадгаш хаягддаг нь ямар эрхтэний үйлийн оролцоотойгоор явагддаг вэ? зөв хариултыг сонгоно уу.

- А. Дэлүү
- В. Давсаг

- C. Бөөр
- D. Ходоод
- E. Элэг

/283./ Ямар зүйлийн эмийг хаврын сүүл зуны эхэнд түүвэл нэн сайн бэ ? зөв хариултыг сонгоно уу.

- A. Жимсний зүйл
- B. Модны зүйл
- C. Цэцгийн зүйл
- D. Үндэсний зүйл
- E. Навчны зүйл

/284./ Задь, саримас, сонгино гэх мэт эмт бодисууд ямар эрдэмтэй эмэнд багтах вэ? Зөв хариултыг сонгоно уу.

- A. Бүлээний эрдэмтэй эм
- B. Тослог эрдэмтэй эм
- C. Хүндийн эрдэмтэй эм
- D. Батлаг эрдэмтэй эм

/285./ Шар махбодын өмхий билиг чанар нь эмийн 17 эрдмийн ямар билиг чанарт дарагддаг вэ? Зөв хариултыг сонгоно уу.

- A. Тослог
- B. Халуун
- C. Шингэн
- D. Сэрүүн
- E. Нүнжиггүй

/286./ Яс, булчин, мах зэрэг биеийн чийрэг бүрэлдэхүүн одон зурхайн таван махбодын аль махбодоос үүсэлтэй вэ? Зөв хариултыг сонгоно уу.

- A. Огторгуй
- B. Шороо
- C. Гал
- D. Ус
- E. Хий

/287./ Гара хэмээх эмийн түүхий эд ямар өвчнийг анагаах эмийн бүлэгт хамаарах вэ ? зөв хариултыг сонгоно уу.

- A. Шарыг арилгах эмийн бодис
- B. Бадганыг арилгах эмийн бодис
- C. Шар усны өвчнийг анагаах эмт бодис
- D. Халууныг арилгах эмийн бодис
- E. Цусны өвчнийг анагаах эмийн бодис

/288./ Сарнисныг хураах, муу цусыг ялгах, хорыг тайлах, хөлөргөх, шээлгэхээр хэрэглэхэд мэдэгдэм үйлдэлтэй эмийг юу гэх вэ?.

- A. талх
- B. үрэл
- C. зуурмал
- D. ханд
- E. тан

/289./ “ Анагаах ухааны 4 үндэс “ – ийн Хойд үндэс хэмээх бүлэгт хүрэлцэх судлаар өвчнийг танин барихын бүлэгт төмөр махбод ямар улиралд дэлгэрэнэ гэж үздэг вэ? Зөв хариултыг сонгоо уу.

- A. Зун
- B. Өвөл
- C. Улирал бүрийн завсар
- D. Намар
- E. Хавар

/290./ Эмийг нухах үед бургихгүй эмт бодист холилдож байсан зүйл нь уусаж гарсанаар эмийн чанар нь сайжирдаг тул номхотгосон эм бол туйлын нарийлаг байхаас гадна шингээлтэнд сайнаар барахгүй гадуур хэрэглэхэд элдэв харш нөлөөгүй.

- A. Жигнэх

- В. Дэвтээх
- С. Нухах
- Д. Чанах
- Е. Тунгаах

/291./ Эмийн халууны хэмжээ нь нилээд бага, эмийн сүмс нь тунгалаг бус бөгөөд үнэр нь сул, амт нь их байдаг ямар тан бэ?

- А. Ширгээх
- В. Дэвтээх
- С. Бүрмэл
- Д. Чанах
- Е. Аль нь ч биш

/292./ Сэмбэрүү-5 талхан эмийн чадлыг сонгоно уу.

- А. Цайвар бор бадгана
- В. Эс боловсорсон
- С. Ходоод хөөх
- Д. Ходоодны хижиг
- Е. Усан хаван

/293./ Монгол эмийн ерийн мэдлэг номонд гишүүний тухай юу гэж бичсэн байдаг вэ.

- А. Гишүүнийг архинд чанаж
- В. Гишүүнийг шатааж
- С. Гишүүнийг хярвастал хуурч
- Д. Гишүүнийг архинд хуурч
- Е. Гишүүний сахал үндсийг шатааж

/294./ Тунгааж номхотгох аргыг ямар чанартай эмт бодисыг номхотгоход хэрэглэх вэ.

- А. Амьтнаас гарах эм
- В. Үндэс, үндэслэг иш
- С. Нарийлаг эмт бодис
- Д. Эрдэс эрдэсийн төрлийн эмт бодис
- Е. Эрдэнийн эм

/295./ Эмт бодисоо тогоон дотор хийж зөөлөн гал буюу дунд зэргийн галаар халаахын хамт тасралтгүй хөдөлгөж, гүн болох, үрийн хальс нь задарч анхилуун үнэртэй болох үед гаргана.

- А. Бага зэрэг хуурах
- В. Шарлатал хуурах
- С. Хярвастал хуурах
- Д. Нүүрс болтол хуурах
- Е. Дангаар хуурах

/296./ Талх эмийн онцлогийг сонгоно уу.

- А. Шингэх хурдац удаан
- В. Шаталт ихтэй
- С. Хүрэлцэх талбай нь их
- Д. Эмийн үйлдэл нь жигд түргэн
- Е. Өнгө, үнэр амт хувирдаг

/297./ Шимжүүлэх тан буюу хатуу бэх чанартай эмт бодисыг хэдэн минут чанах шаардлагатай вэ.

- А. 10-15
- В. 10
- С. 20-25
- Д. 30-40
- Е. 25

/298./ Эрдэс амьтны дун хавтасны зүйл болон чанараар хэврэг, эмт бодисыг номхотгоход тохирно. Зөв хариултыг сонгоно уу.

- А. Шатаах
- В. Шаргаах
- С. Хайлуулах
- Д. Хуйхлах
- Е. Нурамлах

/299./ Гожилийг үнээний айрганд дэвтээгээд үсийг хусаж хэрэглэмүй ямар зохиолд ингэж бичсэн вэ

- A. Гэгээн хөмрөг
- B. Увьдасын үндэс
- C. Арүрийн биндэръяа
- D. Монгол эмийн ерөнхий мэдлэг
- E. Жүрүдошил

/300./ Эмт бодисын аргуулах үйлдлийг нэмэгдүүлэхийн төлөө аль номхотгох аргыг хэрэглэх вэ. Зөв хариултыг сонгоно уу.

- A. Шатааж шүүрүүлэх
- B. Задгай шатаах
- C. Битүү шатаах
- D. Шатааж хуйхлах
- E. Шатааж нурамлах

/301./ Манчинг номхотгохдоо 1.5 кг арүрийг чанасан сүмс 15 литрийг хэрэглэнэ. Хэдэн кг болтол нь манчинг номхотгох вэ.

- A. 10 кг
- B. 12
- C. 8
- D. 5
- E. 4

/302./ Гишүүнийг номхотголгүйгээр хэрэглэвэл ямар үйлдэл үзүүлэх вэ.

- A. Хурж бөөгнөрснийг тараана
- B. Урвуу арилгагч хийн гүйдлийг сайжруулна.
- C. Хүний цусны тунгалагийн эсрэг цогцын урвалыг таслана.
- D. Бактерийг устгана
- E. Ходоодыг хялбар гэмтээнэ.

/303./ Эмт бодисоо эмт сүмс, архи, сүү, шар тос, ус мэтийн шингэн биетэд хийж буцалгахыг

- A. Жигнэх
- B. Хуйхлах
- C. Чанах
- D. Хайлуулах
- E. Шаргаах

/304./ Төвдөөр Дүмдаг гэж нэрлэдэг эмийн ургамлын нэрийг сонго.

- A. Хужир
- B. Вүлдог
- C. Хүнцэл
- D. Хилэнц хорхой
- E. Донрог

/305./ Норов-7 тангийн амт

- A. Гашуун, исгэлэн, эхүүн
- B. Гашуун, исгэлэн, өчүүхэн эхүүн
- C. Гашуун, эхүүн, исгэлэн
- D. Гашуун, эхүүн, өчүүхэн исгэлэн
- E. Гашуун, эхүүн, давслаг

/306./ Сэмбэрүү-5 талхан эмэнд хөл болж ордог Гаварын хальсны төвд нэрийг сонгоно уу.

- A. Шингүн
- B. Шунх
- C. Шинц
- D. Шинца
- E. Шинар

/307./ Мерказолилын үйлдлийн механизмыг олно уу?

- A. Тиреотропны даавар ялгаралтыг багасгана.
- B. Цусан дахь сахарын хэмжээг багасгана.
- C. Инсулины ялгаралтыг ихэсгэнэ.
- D. Бамбай булчирхайн дааварын нийлэгжилтийг дарангуйлна.

- Е. Бамбайн булчирхайн йод шингээлтийг өөрчилнө.
- /308./ Хоол боловсруулах замаар ууж хэрэглэсэн эм хаана цусанд шимэгддэг вэ?
- А. Амны хөндийн салст
 - В. ходоодны салст
 - С. 12 хуруу гэдэс
 - Д. нарийн гэдэс
 - Е. бүдүүн гэдэс
- /309./ Дараах мэдээлэлээс аль нь фуросемидын үйлчлэх хугацаатай тохирохыг олно уу?
- А. Уухад шээлгэх үйлдэл 12 цаг үргэлжлэнэ
 - В. Уухад шээлгэх үйлдэл 6-8 цаг үргэлжлэнэ.
 - С. Уухад шээлгэх үйлдэл 2 хоногийн дараа эхлэнэ.
 - Д. Уухад шээлгэх үйлдэл 3 хоног үргэлжлэнэ.
 - Е. Венийн судсанд тарихад шээлгэх үйлдэл 4 минутын дараа эхэлж 1-2 цаг үргэлжлэнэ.
- /310./ Нойрсуулах эмийн бүрэн зөв тодорхойлолт
- А. Нойр хүргэх боломжийг бүрдүүлдэг ба нойрсолтыг идэвхжүүлдэг эмийн зүйл
 - В. Их тархины гадаргад саатал үүсгэдэг эмийн зүйл
 - С. Төв мэдрэлийн системийг хүчтэй дарангуйлалд оруулдаг эмийн зүйл
 - Д. Физиологийн нойртой адил нойр үүсгэдэг эмийн зүйл
 - Е. Их тархины гадаргад түгээмэл саатал үүсгэж физиологийн нойртой адил нойр үүсгэдэг буюу нойрыг хэвийн болгодог эмийн зүйл
- /311./ Дараах бэлдмэлүүдийн алийг зүрхний үйл ажиллагааны архаг дутагдлын үед хэрэглэх вэ?
- А. Строфантин
 - В. Коргликон
 - С. Дигитоксин
 - Д. Панангин
 - Е. Верапамил
- /312./ Дараах бэлдмэлүүдийн аль нь үрэвслийн эсрэг үйлдэл үзүүдэггүй вэ?
- А. Диклофенак
 - В. Метамизол натри
 - С. Парацетамол
 - Д. Индометацин
 - Е. Фенилбутазон
- /313./ Анальгины олон улсын нэршил аль нь вэ?
- А. Ибупрофен
 - В. Метамизол натрии
 - С. Индометацин
 - Д. Фенилбутазон
 - Е. Ацетилсалицилын хүчил
- /314./ Дараах бэлдмэлүүдийн аль нь дархлаа дарангуйлах үйлдэлтэй вэ?
- А. Инсулин
 - В. Тиреоидин
 - С. Преднизолон
 - Д. Метилтестостерон
 - Е. Синэстрол
- /315./ Калийн хлоридын аритмийн эсрэг үйлдлийн механизмыг хэлнэ үү?
- А. Зүрхний булчингийн эсийн мембраны ион нэвтрүүлэх чадварыг бууруулна
 - В. Ацетилхолинтай адил үйлдэл үзүүлнэ
 - С. Тэнэгч нервийн сэрлийг хориглоно
 - Д. Симпатикийн сэрлийг идвэхжүүлнэ
 - Е. Кальцийн сувагт хориг үүсгэнэ
- /316./ Дараах бэлдмэлүүдээс аль алиныг тиреотоксикоз-ын эмчилгээнд хэрэглэх вэ?
- А. Прогестерон
 - В. Гидрокортизон
 - С. Инсулин
 - Д. Мерказолил

- Е. Карбутаид
- /317./ Холинорецептор ямар медиаторыг мэдэрдэг вэ?
- А. Норадреналин
 - В. Адреналин
 - С. Ацетилхолин
 - Д. Аденозин
 - Е. Дофамин
- /318./ Зүрхний гликозидын бүрэн зөв тодорхойлолтыг сонгол ол.
- А. Зүрхний булчингийн агшилтыг хүчтэй болгодог эмийн зүйл.
 - В. Ургамлын гаралтай азот агуулаагүй органик нэгдэл
 - С. Гликон, агликон 2 хэсгээс тогтсон ургамлын гаралтай органик нэгдэл.
 - Д. Ургамлын гаралтай гликон агликон 2 хэсгээс тогтсон., зүрхний булчинд сонгомол нөлөө үзүүлдэг азот агуулаагүй органик нэгдэл.
 - Е. Ургамлын гаралтай гликон агликон 2 хэсгээс тогтсон зүрхэнд сонгомол нөлөө үзүүлдэг органик нэгдэл
- /319./ Циклооксигеназа ямар үүрэгтэй вэ?
- А. Фосфолипидээс цагирагт эндопероксид үүсгэнэ
 - В. Фосфолипидээс арахидоны хүчил үүсгэнэ
 - С. Цагирагт эндопероксидоос арахидоны хүчил үүсгэнэ
 - Д. Цагирагт эндопероксидоос простогландин үүсгэнэ
 - Е. Арахидоны хүчлээс цагирагт эндопероксид үүсгэнэ
- /320./ Нитроглицерины үйлдлийн эхлэх ба үргэлжлэх хугацааг хэлнэ үү?
- А. 10-15 минутад үйлдэл илэрч, 3-4 цаг үргэлжлэнэ
 - В. 20-30 минутад үйлдэл илэрч, 4-6 цаг үргэлжлэнэ
 - С. 1 цагийн дараа үйлдэл илэрч, 6-8 цаг үргэлжлэнэ
 - Д. 1-3 минутад үйлдэл илэрч, 20-30 минут үргэлжлэнэ
 - Е. 5 минутын дараа үйлдэл илэрч, 1-2 цаг үргэлжлэнэ
- /321./ Дараах мэдээллүүдийн аль нь буруу вэ?
- А. Гормоныг зөвхөн гормоны дутагдлын үед хэрэглэнэ.
 - В. Гормоныг гормоны дутагдалтай холбоогүй эмгэгт хэрэглэж болно.
 - С. Гормон эхлээд эсийн цитоплазмын мембранд нөлөөлнө.
 - Д. Зарим гормон эсийн мембраны гадаргууд орших өвөрмөц рецепторт нөлөөлнө.
 - Е. Зарим гормоныг амьтны эрхтэн, шээснээс гаргаж авна.
- /322./ Дараах дотоод шүүрлийн булчирхайнуудын аль нь стероид бүтэцтэй даавар ялгаруулдаг вэ?
- А. Сэрээ булчирхай
 - В. Бэлгийн булчирхай
 - С. Бамбай булчирхай
 - Д. Нойр булчирхай
 - Е. Бамбайн ойролцоох булчирхай
- /323./ Альдостеронд эсрэг нөлөөлж шээлгэх үйлдэлтэй эмийг ол.
- А. Фуросемид
 - В. Спиринолактон
 - С. Гипотаизид
 - Д. Ацетазоламид
 - Е. Манитол
- /324./ Пенициллины бүлгийн антибиотикүүдийн үйлдлийн механизмыг хэлнэ үү?
- А. Нянгийн эсийн доторх уургийн нийлэгжилийг саатуулна
 - В. Нянгийн эсийн доторх уургийн нийлэгжилийг идэвхжүүлнэ
 - С. Нянгийн эсийн ханын нийлэгжилийг саатуулна
 - Д. Нянгийн эсийн ханын нийлэгжилийг идэвхжүүлнэ
 - Е. РНК-гийн нийлэгжилийг саатуулна.
- /325./ Дараах бэлдмэлүүдийн аль нь бөөрний дээд булчирхайн гормоны бүлэгт орох вэ?
- А. Преднизолон
 - В. Тималин
 - С. Карбутаид

- D. Мерказолил
E. Буформин
- /326./ Дараах мэдээллээс аль нь дихлортиазидын үйлдэлтэй тохирохыг олно уу?
A. Цусанд кали, магни, кальци багасаж, урат ихсэнэ.
B. Шээсэнд натри, хлор, кали, магни ихсэж, кальци ихэснэ.
C. Цусанд кали, магни багасаж, кальци, глюкоз ихсэж шээлгэх үйлдэл үзүүлнэ.
D. Шээсэнд натри, хлори, кали, магни, кальци, урат багасна.
E. Цусанд кали ихсэх, натри, хлор шээсэнд ихсэнэ.
- /327./ Аритмийн эсрэг ямар эм зүрхний булчингийн эсийн мембраныг бэхжүүлдэг вэ?
A. Лидокайн
B. Хинидин сульфат
C. Прокаинамид
D. Калийн хлорид
E. Верапамил
- /328./ Бөөрний осмос даралтад нөлөөлөх шээлгэх эмийг зөв ол.
A. Фуросемид
B. Манитол
C. Дихлортиазид
D. Ацетазоламид
E. Спиринолактон
- /329./ Дараах эмүүдийн аль нь ходоодны хүчиллэгийг саармагжуулдаггүй вэ?
A. Натрийн гидрокарбонат
B. Магнийн исэл
C. Алмагель
D. Натрийн сульфат
E. Алюмины гидро- окись
- /330./ Судсанд тарих хүчтэй биш үйлдэлтэй эмийг 1 минутанд хэдэн миллилитр орохоор тооцох вэ?
A. 0.5- 1 мл
B. 1- 2 мл
C. 2-4 мл
D. 3- 4 мл
E. 4- 5 мл
- /331./ Шээлгэх эмийн бүрэн зөв тодорхойлолтыг олно уу?
A. Давсагны шээсээ хөөн гаргах үйл ажиллагааг сайжруулах эм
B. Бөөрний шээс ялгаруулах ажиллагааг ихэсгэх эм.
C. Бөөрний түүдгэнцэрийн шээс шүүрүүлэх ажиллагааг идэвхжүүлэх.
D. Эрдэс усны солилцоонд нөлөөлж бөөрөөр гадагшлах шээсний хэмжээг ихэсгэх үйлдэлтэй эм.
E. Альдостероныг дарангуйлах эм.
- /332./ Гистамины H₂ - рецепторт хориг үүсгэдэг эмийг нэрлэнэ үү?
A. Дифенгидрамин
B. Прометазин
C. Хлоропирамин
D. Клемастин
E. Ранитидин
- /333./ Нейролептикууд ямар үйлдэл үзүүлдэг вэ?
A. Сэтгэл хөдлөлийг намдаана
B. Сэтгэц тайвшруулах, солиорлын эсрэг
C. Сэрэл, саатлыг тохируулах
D. Сэтгэл уналтын эсрэг
E. Сэтгэл засах
- /334./ Дараах бэлдмэлүүдийн аль нь эм бэлгийн дааварын бэлдмэлүүд вэ?
A. Тироидин
B. Тиамазол
C. Преднизолон

- D. Прогестерон
E. Буформин
- /335./ Ямар эмийн бэлдмэл кальцийн сувагт хориг үүсгэдэг вэ?
A. Прокаинамид
B. Хинидин сульфат
C. Дигоксин
D. Верапамил
E. Панангин
- /336./ Энтеробиозын үед ямар эмийн бэлдмэлийг хэрэглэх вэ?
A. Фенасал
B. Метронидазол
C. Мебендазол
D. Интерферон
E. Бүгдийг
- /337./ Дараах бэлдмэлүүдийн аль нь харшлын эсрэг үйлдэлтэй вэ?
A. Эстрадиол
B. Кальцитонин
C. Инсулин
D. Метилтестостерон
E. Кеналог
- /338./ Дараах бэлдмэлүүдийн аль аль нь хамгийн удаан ялгарч биед хуримтлагдах вэ?
A. Стропантин
B. Коргликон
C. Дигоксин
D. Дигитоксин
E. Адонисын бэлдмэлүүд
- /339./ Ампициллины үйлдлийн хүрээг нэрлэнэ үү?
A. Өргөн хүрээний үйлдэлтэй, хагас нийлэг антибиотик
B. Грам эерэг нянд сайн нөлөөлнө
C. Грам сөрөг нянд сайн нөлөөлнө
D. Удаан үйлдэлтэй антибиотик
E. Бүгд зөв
- /340./ Бага насны хүүхдэд тосонд уусамхай /липофиль/ эмүүдийн тархалтын эзлэхүүн /Vd/ хэрхэн өөрчлөгддөг вэ?
A. Багасна
B. Багасах буюу өөрчлөгдөхгүй
C. өөрчлөгдөхгүй
D. өөрчлөгдөхгүй буюу ихэснэ
E. Ихэснэ
- /341./ Эмийн зохистой хэрэглээтэй холбоотой дараах мэдээллүүдийн аль нь буруу вэ?
A. Улсын бүртгэлд бүртгэгдсэн бүх эмийг тус улсын нутагт зарж борлуулж болно.
B. Жоргүй олгож болох эмийг тус улсын нутгийн аль ч хэсэгт зарж борлуулж болно.
C. Зайлшгүй шаардлагатай эмийг хэрэглэх эмнэлгийн шатлалаар нь 4 зэрэг болгодог.
D. Хорт мансууруулах нөлөөт эмийг зөвхөн тусгай хяналтаар зарцуулна.
E. Уламжлалт эмийг категорчилалын дагуу хэрэглэх ёстой.
- /342./ Антибиотик хэрэглэсний улмаас хүүхдийн ясжилт өөрчлөгдөн шүдний өнгө нь шарлажээ. Дараах антибиотикүүдээс алийг нь хэрэглэж байсан байж болох вэ
A. Ампициллин
B. Гентамицин
C. Цефоперазон
D. Эритромицин
E. Тетрациклин
- /343./ Дараах эмийн хослолуудаас ходоодны шархлааны эмчилгээнд хэрэглэдэг “сонгодог гурвал”-ыг олно уу?
A. Циметидин Амоксациллин Коллоид висмут
B. Ранитидин Амоксациллин Коллоид висмут

- C. Метронидазол Амоксациллин Коллоид висмут
D. Алмагель Амоксациллин Коллоид висмут
E. Циметидин Метронидазол Коллоид висмут
- /344./ Нифедипины биохүрэхүй /F/ бага байдгийн шалтгааныг ол.
A. Элгэнд системийн өмнөх элиминаци-д ордог
B. Шимэгдэлт муутай
C. Цусны плазмын уурагтай холбогддог
D. Ходоод гэдэсний замд идэвхгүйждэг
E. Биеээс хурдан ялгардаг
- /345./ Теофиллины цусны плазм дахь эмчилгээний дундаж тун:
A. 10-20 мкг/мл
B. 25-30 мкг/мл
C. 30-35 мкг/мл
D. 35-40 мкг/мл
E. 5-10 мкг/мл
- /346./ Тетрациклиныг ходоодны хүчил саармагжуулах эмүүдтэй хамт хэрэглэвэл түүний микробын эсрэг нөлөө буурдаг. Үүний шалтгааныг олно уу?
A. Тетрациклины шимэгдэлт саатна
B. Тетрациклины хувирал түргэснэ
C. Тетрациклины ялгаралт түргэснэ
D. Тетрациклины тархалтын эзлэхүүн багасна
E. Тетрациклины $t_{1/2}$ богиносно
- /347./ Уртасгасан үйлдэлтэй үрэвслийн эсрэг нөлөөт эмийг нэрлэнэ үү?
A. Аспирин
B. Анальгин
C. Пироксикам
D. Индометацин
E. Ортофен
- /348./ Ходоодны секрецийг хамгийн сайн дарангуйлах нөлөөтэй бэлдмэлийг нэрлэнэ үү?
A. Омепразол
B. Циметидин
C. Фамотидин
D. Сукральфат
E. Пиренципин
- /349./ Жирэмсэн эхэд бетта-адреноблокаторыг хэрэглэсний улмаас нярайд ямар хүндрэл үүсч болох вэ?
A. Сонсгол муудах
B. Арьсны гэмтэл
C. Эхэс ба ургийн гипотрофи
D. Боталлов цорго хугацаанаас өмнө битүүрэх
E. Цусархаг хам шинж илрэх
- /350./ Ревматоид артриттай, гуурсан хоолойн багтрааны рисктэй өвчтөнд дараах эмүүдээс алинаас бусдыг нь хэрэглэж болох вэ?
A. Диклофенак
B. Ибупрофен
C. Индометацин
D. Делагил
E. Ацетилсалицилийн хүчил
- /351./ Ревматоид полиартрит өвчний улмаас стероид бус үрэвслийн эсрэг нөлөөт эмийг удаан хугацаагаар хэрэглэж буй өвчтөнд ходоодны шархлаа үүсэхээс сэргийлэхийн тулд ямар эмийг хэргэлэж болох вэ?
A. Сукральфат
B. Гастроцепин
C. Ранитидин
D. Маалокс
E. Мизопростол

/352./ Эмийн бэлдмэлүүдийн уурагтай холбогдолт ямар хүчин зүйлээс хамаарах вэ?

- A. Эм хэрэглэх аргаас
- B. Физик химийн шинж чанараас
- C. Эмийн хэлбэрээс
- D. Эм бэлтгэх технологоос
- E. Өвчтөний биеийн байдлаас

/353./ Өндөр настай өвчтөнд усанд уусамхай /гидрофиль/ эмүүдийн тархалтын эзлэхүүн /Vd/ хэрхэн өөрчлөгддөг вэ?

- A. Багасна
- B. Багасах буюу өөрчлөгдөхгүй
- C. өөрчлөгдөхгүй
- D. өөрчлөгдөхгүй буюу ихэснэ
- E. Ихэснэ

/354./ Ямар өвчний үед пропранололыг хэрэглэж болохгүй вэ?

- A. Элэгний циррозтой өвчтөнд
- B. Бөөрний архаг дутагдалтай өвчтөнд
- C. Гуурсан хоолойн багтраа
- D. Чихрийн шижин
- E. Ходоод гэдэсний шархлаатай бол

/355./ Аминофиллины үйлдлийн үргэлжлэх хугацаа хэдэн цаг байдаг вэ?

- A. 1-2 цаг
- B. 2-3 цаг
- C. 3-4 цаг
- D. 6-8 цаг
- E. 10-12 цаг

/356./ Лидокаины эмчилгээний зохистой концентраци нь цусны плазм-д 3 мг/л байдаг. 60 кг жинтэй өвчтөнд түүнийг судсаар тарьж хэрэглэх болов. Цохилтын тунг тооцон олно уу?

- A. 134 мг/мин.
- B. 540 мг
- C. 5.4 мг
- D. 54 мг
- E. 11.34 мг/мин

/357./ Пропранололтой шууд антагонист үйлдэлтэй эмийг нэрлэ.

- A. Гидрохлортиазид
- B. Резерпин
- C. Фуросемид
- D. Изодреналин
- E. Метилдопа

/358./ Богино үйлдэлтэй бетта-2-адреномиметикийг олно уу?

- A. Сальбутамол
- B. Аминофиллин
- C. Ипратропиум бромид
- D. Орципреналины сульфат
- E. Сальметерол

/359./ Нярай хүүхдийн эмийн кинетик ба динамикийн тухай дараах мэдээллүүдийн аль нь буруу вэ?

- A. Тархалтын эзлэхүүн /Vd/ бага байна
- B. Эмийн хагас элиминацийн хугацаа $t_{1/2}$ удаан байна
- C. Элгэн дэх эмийн хувиралын эрчим сул байна
- D. Адренорецепторууд бүрэн ялгаран хөгжиж чадаагүй байдаг
- E. Эмийн клиренс удаан байна.

/360./ M1-холинорецепторыг сонгомлоор хориглон ходоодны секрецийг дарангуйлах нөлөөтэй бэлдмэлийг нэрлэнэ үү?

- A. Омепразол
- B. Циметидин
- C. Фамотидин

- D. Сукральфат
 - E. Пиренципин
- /361./ Удаан үйлдэлтэй бетта-2-адреномиметик эмийн нэрийг ол.
- A. Сальбутамол
 - B. Тербуталин
 - C. Фенотерол
 - D. Орципреналины сульфат
 - E. Формотерол
- /362./ Доорхи эмүүдээс хамгийн удаан үйлдэлтэй үрэвслийн эсрэг нөлөөт эмийг нэрлэнэ үү?
- A. Аспирин
 - B. Анальгин
 - C. Пироксикам
 - D. Индометацин
 - E. Ортофен
- /363./ Атровентийг ингаляцаар хэрэглэхэд ямар гаж нөлөө олонтаа илрэх вэ?
- A. Остеопороз үүсэх
 - B. Ханиалгах
 - C. Амны хөндий ба залгиурын кандидоз үүсэх
 - D. Өтгөн хатах
- /364./ Салицилатуудыг хэрэглэж байхад ямар гаж нөлөө илэрч болох вэ?
- A. Ходоодны шарх үүснэ
 - B. Сонсголын мэдрэл гэмтэнэ
 - C. Ясжилт өөрчлөгдөнө
 - D. Бөөрний дутагдал үүснэ
 - E. Ургийн гаж хөгжил үүснэ
- /365./ 5-изосорбид мононитрат, изосорбид динитратаас юугаараа ялгаатай вэ?
- A. Элгээр өнгөрөхдөө системийн өмнөх элиминаци-д өртдөггүй
 - B. Дасал үүсдэггүй
 - C. Метгемоглобин үүсгэдэггүй
 - D. Толгой өвтгөдөггүй
 - E. Тэдгээрийн хооронд ялгаа байхгүй
- /366./ Эмийг ямар аргаар хэрэглэхэд системийн өмнөх элиминаци хамгийн их байх вэ?
- A. Венийн судсаар тарих
 - B. Хэлэн дор тавих
 - C. Булчинд тарих
 - D. Уух
 - E. Шулуун гэдсээр хэрэглэх
- /367./ Артерийн даралтын зохицуулгад PAC-ийг саатуулах механизмаар нөлөөлж артерийн даралт бууруулдаг эмийг нэрлэнэ үү?
- A. Клонидин
 - B. Каптоприл
 - C. Миноксидил
 - D. Гуанетидин
 - E. Гидрохлортиазид
- /368./ Агааргүйтэний эсрэг хамгийн идэвхитэй нөлөөлөх эмийн бэлдмэлийг олно уу?
- A. Ампициллин
 - B. Гентамицин
 - C. Цефоперазон
 - D. Метранидазол
 - E. Тетрациклин
- /369./ Пропранололын биохүрэхүй /F/ бага байдгийн шалтгааныг олно уу?
- A. Элгэнд системийн өмнөх элиминаци-д ордог
 - B. Шимэгдэлт муутай
 - C. Цусны плазмын уурагтай холбогддог
 - D. Ходоод гэдэсний замд идэвхгүйждэг
 - E. Биеээс хурдан ялгардаг

/370./ Дараах эмүүдийн алинаас бусад нь теофиллины цусан дахь концентрацийг бууруулах вэ?

- A. Фенобарбитал
- B. Рифампицин
- C. Карбамазепин
- D. Нифедипин
- E. Фенитоин

/371./ Тамхи ихээр татдаг өвчтөнд теофиллины биотрансформаци хэрхэн өөрчлөгдөх вэ?

- A. Багасна
- B. Багасах буюу өөрчлөгдөхгүй
- C. өөрчлөгдөхгүй
- D. өөрчлөгдөхгүй буюу ихэснэ
- E. Ихэснэ

/372./ Зүрхний гликозидыг дараах эмүүдийн алинтай нь хамт хэрэглэж болохгүй вэ?

- A. Спинолактон
- B. Кальци хлорид
- C. Витамин В комплекс
- D. Кали хлорид
- E. Гемодез

/373./ Системийн халдвартай өвчтөнд антибиотик хэрэглэх болов. Уг өвчтөний биед байнга агуулагдвал зохих антибиотикийн хэмжээ 300 мг болно. Эмийн $t_{1/2} = 8$ цаг бол уг эмийг яаж хэрэглэвэл зохих вэ?

- A. 100 мг-аар 8 цагаар
- B. 200 мг-аар 8 цагаар
- C. 300 мг-аар 8 цагаар
- D. 400 мг-аар 8 цагаар
- E. 600 мг-аар 8 цагаар

/374./ Хамт хэрэглэсэн хоёр эмийн аль нэг нь нөгөөгөө цусны плазмын уургаас түрвэл дараах нөлөөнүүдээс аль нь үүсч болох вэ?

- A. Түрэгдсэн эмийн $t_{1/2}$ уртсана
- B. Түрэгдсэн эмийн тархалтын эзлэхүүн V_d ихэснэ
- C. Түрэгдсэн эмийн чөлөөт хэсгийн концентраци ихэснэ
- D. Түрэгдсэн эмийн эмчилгээний нөлөө ихэснэ
- E. Түрсэн эмийн эмчилгээний нөлөө ихэснэ

/375./ Уртасгасан үйлдэлтэй глюкокортикоидыг нэрлэнэ үү?

- A. Преднизолон
- B. Полькортолон
- C. Дексаметазон
- D. Кеналог
- E. Метилпреднизолон

/376./ 65 кг жинтэй өвчтөний нойргүйдлийн эмчилгээнд фенобарбиталийг хэрэглэх болов. Түүний барих тунг тооцон олоод хэрэглэх дэглэмийг тогтооно уу?

- A. 910 мг-аар өдөрт нэг удаа
- B. 130 мг-аар өдөрт 2 удаа
- C. 91 мг-аар өдөрт 2 удаа
- D. 130 мг-аар өдөрт нэг удаа
- E. 260 мг-аар өдөрт 1 удаа

/377./ Зүрхний шигдээсийн улмаас өвчтөнд ховдолын гаралтай экстрасистол үүсчээ. Дараах эмүүдээс алийг нь сонгон хэрэглэвэл зохих вэ?

- A. Верапамил
- B. Пропранолол
- C. Лидокаин
- D. Хинидин
- E. Дигоксин

/378./ Дараах эмүүдээс алийг нь хэрэглэвэл паркинсоны хам шинж үүсэх вэ?

- A. Диазепам

- В. Леводоба
- С. Фенобарбитал
- Д. Галоперидол
- Е. Аминофилин

/379./ Глюкокортикоидуудыг ингальяцаар хэрэглэхэд ямар гаж нөлөө олонтаа илрэх вэ?

- А. Остеопороз үүсэх
- В. Гиперкортицизм
- С. Амны хөндий ба залгиурын кандидоз үүсэх
- Д. Артерийн даралт ихсэх
- Е. Хавагнах

/380./ Нифедипинийг ямар тохиолдолд хэрэглэж болохгүй вэ?

- А. Артерийн даралт ихсэх
- В. Зүрхний дутмагшил
- С. Бронхийн багтраа
- Д. Артерийн даралт багасалт
- Е. АВ-хориг 2-р зэрэг

/381./ Кардиоселектив бетта-адреноблокаторыг нэрлэнэ үү?

- А. Пропранолол
- В. Атенолол
- С. Изопреналин
- Д. Фентоламин
- Е. Арфонад

/382./ Салметеролын үйлдлийн үргэлжлэх хугацаа:

- А. 1-2 цаг
- В. 2-3 цаг
- С. 3-4 цаг
- Д. 6-12 цаг
- Е. 18-24 цаг

/383./ Дараах эмүүдээс аль нь пенициллиний бөөрний сувганцарын секрецийг хориглодог вэ?

- А. Диазепам
- В. Гентамицин
- С. Рифампицин
- Д. Пробенецид
- Е. Хинидин

/384./ Жинхэнэ гипертони өвчний эхний ээлжийн эмчилгээнд дараах эмүүдээс алийг нь эхэлж хэрэглэх вэ?

- А. Клофелин
- В. Адельфан
- С. Гидрохлортиазид
- Д. Метилдофа
- Е. Гуанетидин

/385./ Бронхийн багтрааны эмчилгээнд преднизолон ба теопек-ийг байнга ууж, беротек-ийг ингальяцаар хэрэглэж байсан өвчтөн бронх-уушигны халдварын улмаас эритромицин болон бромгексин-ийг нэмж хэрэглэжээ. Гурав дахь өдрөөс өвчтөний толгой өвдөж, тайван бус болж, зүрх нь дэлсэж, зүрх орчмоор нь эвгүй болон айдас төрж, артерийн даралт нь бууран, халуурч, огиудас ба бөөлжис цутгах болов. Эдгээр шинж тэмдгүүд ямар эмийн хортой нөлөөнөөс шалтгаалсан бэ?

- А. Преднизолон
- В. Теопек
- С. Эритромицин
- Д. Беротек
- Е. Бромгексин

/386./ Ямар эм хеликобактериозын үед илүү идэвхтэй нөлөөлөх вэ?

- А. Ранитидин
- В. Оксациллин

- C. Де-нол
- D. Де-нол+ампициллин /амоксациллин/
- E. Маалокс

/387./ Пропранололыг дараах эмүүдийн алинтай нь хамт хэрэглэж болохгүй вэ?

- A. Верапамил
- B. Гидрохлортиазид
- C. Нифедипин
- D. Каптоприл
- E. Нитросорбид

/388./ Жирэмсэн үед микробын эсрэг нөлөөт эмүүдээс алийг нь хэрэглэвэл хор нөлөө хамгийн бага байх вэ?

- A. Аминогликозидууд
- B. Ко-тримоксазол
- C. Нитрофуранууд
- D. Пенициллинүүд
- E. Фторхинолоныуд

/389./ Шугаман кинетиктэй $t_{1/2} = 6$ цаг бүхий эмийг венийн судсаар нэг удаа тарьж хэрэглэснээс хойш 20 цагийн дараа биед эмийн хэдэн хувь нь үлдэх вэ?

- A. 25%
- B. 10%
- C. 15%
- D. 5%
- E. 6.25%